

СОЁЛЫН ДАЯАРШИЛ МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

Б. Цолмон*

Даяаршин буй ертөнцийн нэгэн зүй тогтолт үйл явц нь соёлын даяаршил юм. Энэхүү үйл явц өнө хожид мартагдашгүй уламжлалтай монголын үндэсний соёлын хувь заяанд хэрхэн тусах асуудал эдүгээ монголын ард түмний түүх, соёлыг хүндэтгэдэг хэн бүхний анхаарлыг татах болжээ. Монгол соёл иргэншил оршин тогтнохын асуудал бол Монгол улсын үндэсний язгуур ашиг сонирхлын¹ нэг юм. Тиймээс Монголын соёл иргэншлийн аюулгүй байдал хангагдаж чадаж байна уу гэсэн асуудал бидний өмнө аяндаа тулгарч байна. Үүнийг бодон дараахи хэдэн асуудлыг хөндье.

Монголчууд мэдлэг мэдээлэл, техник технологи, худалдаа эдийн засаг, ардчиллын үнэт зүйлсээр улам бүр дэлхий дахины нийтлэг горимд тэмүүлж байгаагаараа даяаршлын үйл явцыг дэмжиж байна. Харин нөгөө талаас үндэсний соёлын элементүүд бүдгэрэх, харь соёлын нөлөөлөл газар авахаас болгоомжилж байгаагаараа даяаршлын асуудалд эргэлзэнгүй буюу шүүмжлэлтэй хандаж байна. Үнэхээр ч даяаршлын үйл явц цаашид гүнзгийрэх нь тодорхой боллоо.

Даяаршлын үйл явц, түүний сөрөг үр дагавраас зайлсхийх аргагүй тийм цаг үед нэгэнт оршин амьдарч байгаагийн хувьд бид үндэснийхээ дархлалыг бий болгох механизмыг бүрдүүлж хөгжүүлэх нь тулгамдсан асуудал мөнөөс мөн билээ.

Манай улс 1994 оны Үндэсний Аюулгүй Байдлын үзэл баримтлалдаа: *“Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал гэж монгол түмэн, монгол төр оршин тогтнож хөгжихийн үндэс болсон үндэсний хэл бичиг, түүх соёл, зан заншил хадгалагдах, монгол хүн ард үүрд оршин амьдрах нөхцөл хангагдсан байдлыг хэлнэ”*²

* МУИС-ийн ОУХС-ийн магистр

¹ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2002

² Аюулгүй байдлын үзэл баримтлал 2002

гэжээ. Үнэхээр ч Монгол улс үндэснийхээ аюулгүй байдлыг хангахад өөрийн өвөрмөц соёл иргэншлийн өвийг сахин хамгаалах, уламжлан хадгалах асуудлыг тэргүүлэх чиглэлд авч үзэх шаардлагатай.

ҮАБ-ын үзэл баримтлалд “Улс орны үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын үзэл бодлын үндэс нь эх оронч үндэсний үзэл байх”³-аар тодорхойлжээ. Чухамхүү даяаршлын сөрөг үр дагавраас хамгаалах үндэсний дархлалыг бий болгоход зайлшгүй чухал хүчин зүйлд үндэсний эх оронч үзэл, хүмүүжил зүй ёсоор орно. Эх оронч үзэл, хүмүүжлийн үндэс суурь нь үндэсний үзэл, бахархал билээ. Үүнийг ч Монгол улсын ерөнхийлөгч Н.Багабанди “Монгол ухаан” номдоо: “*Үеийн үед голомтоо сахих монгол түмэн, үндэс угсаагаараа бахархана, үрэгдэж, хорогдсон ч өнө хожид давтагдашгүй соёл, уламжлал, заншлын эрхэм нандин өвөөрөө бахархана*” хэмээжээ.

Үндсэн Хуулиндаа ч мөн Монгол улсын язгуур ашиг сонирхолд “... *Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнохыг*” оруулахаар заасан. Гэтэл эдүгээ үндэсний язгуур эрх ашгийн эрхэм үнэт зүйл болсон эх оронч үндэсний үзэл, хүмүүжил сулрах, бүдгэрэх аюул учирч буйг цөөнгүй баримт харуулж байна. Үүний уршгаар даяарших үзэл гэгч мөн чанартаа “*эх оронч үзэл*”-ийг ихээхэн саармагжуулах хүчин зүйл болоод байна гэж үзэх эрдэмтэн⁴ судлаачид ч мөн бий. Харин энд нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд, эх оронч үзэл хүмүүжил суларч, бүдгэрэх аюул зөвхөн гаднаас нөлөөлж байна гэвэл нэг ёсны туйлшрал болно. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулийн сургалтанд энэ асуудлаар хоосон орон зай байгаа нь бидэнд дотооддоо бодлогын хүрээнд шийдвэрлэх олон асуудал буйг харуулж байна. Иймд улс орны нийгэм, эдийн засгийн байдлын улмаас иргэдийн эх оронч сэтгэлгээ алдагдах нь аюулгүй байдлыг хангахад сөргөөр нөлөөлөх бас нэгэн хүчин зүйл болохыг санууштай.

Эдүгээ Азийн суурин соёл иргэншилтэй бусад орнууд, тухайлбал Япон хийгээд Солонгосын нөлөө Монголд нэвтэрч буйн зэрэгцээ өрнөдийн ч соёл иргэншлийн нөлөөнд хүчтэй орж байгаа нь илт байна. Ийнхүү нүүдлийн соёл иргэншил нь суурин соёл иргэншилтэй нэгдэн уусах үйл явц хүчтэй ажиглагдах боллоо. Үүнийг харин нүүдлийн соёл иргэншил цаг үеэ өнгөрөөсөн, хоцрогдсон гэж шоовдорлох хандлага ч өөгшүүлж байна. Монгол улсын хувьд нүүдлийн соёл

³ Аюулгүй байдлын үзэл баримтлал 2002

⁴ Л.Түдэв “Диалектик ба ҮАБ” 2002 Стратеги судлал, ССХ. УБ

иргэншлийн онцлог, давуу талуудыг дэлхийн болон бүс нутгийн нийтлэг соёл, амьдралын хэв маягтай зөв хослуулах асуудал улам бүр чухлаар тавигдаж байна.

Монгол улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд “...суурин ба нүүдлийн амьдралын хэв маягийг оновчтой хослуулах”⁵-аар заасанчлан соёлын болон нийгмийн тогтвортой хөгжлийг хослуулах нь чухал гэж үзэж байна. Ийнхүү Монгол улс Гадаад Бодлогын Үзэл Баримтлал дахь соёл, хүмүүнлэгийн гадаад харилцааны зорилгодоо тодорхойлсончлон Монгол туургатны соёл иргэншлийг хамгаалах, соёлын өвөрмөц өв уламжлалыг арвижуулж, дэлхийн соёлын нийтлэг ололтоор баяжуулхад соёлын хамтын ажиллагааг чиглүүлэх, улс түмнийг танин мэдэх, тэдэнтэй харилцан ойлголцох, итгэлцэх явдлыг нэмэгдүүлэх шаардлага урган гарч байна.

Хэдийгээр соёлын даяаршил “нэг хэмжээ бүгдэд тохирно” (*one size fits all*) буюу нэг л маягийн загварыг нийтэд түгээн дэлгэрүүлэхийг зорьдог ч барууны соёл иргэншлийг “хэт дөвийлгөн хуулбарлах” нь тэдгээртэй уламжлал, хэл, соёл, хөгжлийн түвшинг нь авч үзвэл адилгүй улс орны хувьд тэдний эдийн засаг, нийгэм, соёлын хүрээнд сөргөөр нөлөөлж, ялангуяа уламжлалт соёл, үндэсний гэх өвөрмөц онцлогоо алдахад хүрч, улмаар харь улсын жишгийг дагасан нийтлэг нэг төрх л Монголд үлдэх вий гэсэн болгоомжлолыг төрүүлнэм. Харин өөрийн эдийн засаг, соёлын онцлогт тохируулан нэмэлт арга хандлага болгох нь зүй ёсны байж болох талтай.

Манай ҮАБ-ын үзэл баримтлалд “...бусад ард түмний соёл иргэншлийг хэт дөвийлгөн сохроор хуулбарлах...”⁶ нь соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангахад сөргөөр нөлөөлнө гэж үзсэн. Гэтэл хэзээний содон монголчууд өдөр ирэх бүр өрнө, дорны хүмүүсийн нэгэн ижил хувцас, хоол унд, унаа, сууц, хэрэглээтэй болоод зогсохгүй тэдний адил ярьдаг, бодож сэтгэдэг болохыг ч хичээж байгаа нь “*Globalization*”, “*Westernization*”, “*Americanization*”, “*McDonaldization*”-ны давалгаанд хэт автагдсаны тод илрэл биш үү. Тухайлбал, Америк гаралтай тоглоом, Холливудын кино, түргэн хоолны цэгүүд, поп хөгжим зэргийг дурьдаж болно. Иймэрхүү соёлын интервенц ч гэж нэрлэгддэг үйл явц нь улс үндэстнүүдийн соёлын ялгааг арилгаж, нэгдсэн нэг соёлт амьдрал төлөвшүүлэхийг зорьж буйн дээр хүнийг хэрэглээний далайд живүүлэн адилтгаад зогсохгүй хүнийг хүнд нь живүүлж чадна

⁵ Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал 2000

⁶ Аюулгүй байдлын үзэл баримтлал 2002

гэдгээ ч нотлож буй гэлтэй. Хэдийгээр энэ байдлыг буруутгалгүй, харин ч улам бүр соёлжин, дэлхийн хөгжингүй орны залуустай мөр зэрэгцэн алхах боломж олдож буйн илрэл хэмээн үзэж болох авч цаашдаа энэ нь уламжлалт соёл, үндэсний гэх онцлогоо алдахад хүрч, улмаар харь улсын жишгийг дагасан нийтлэг нэг төрх л Монголд үлдэх вий гэсэн болгоомжлолыг төрүүлнэм.

Иргэдийн шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хуульчлан бататгаж, төр сүм хийдийн харилцааг хуулиар зохицуулах явдал бол даяаршлын үед үндэсний аюулгүй байдлыг хангах нэг чухал механизм. Шашин нь соёлын элементийг дэлхий нийтийн болгоход чухал үүрэгтэй боловч эргээд соёлын ба шашин хоорондын зөрчлийг дэвэргэж болзошгүй үр дагавартай байдаг. Иймд аль нэг шашныг хэт өргөмжлөн бусдад тулгах, эсхүл хэт үгүйсгэн тусгаарлах нь нийт хүн төрөлхтний шинжтэй даяаршлын үнэт зүйл, эерэг үр дүнг хохирооход хүргэж болзошгүйг бодуштай. Эдүгээ Монголд уламжлалт бус шашны олон арван урсгал нэвтэрч, төр сүм хийдийн харилцаа ба шашин хоорондын харилцааны хүрээнд хуулиар нарийвчлан тогтоох шаардлагатай цөөнгүй асуудал хуримтлагдаад байна. Тухайлбал, өнөөдөр манай улсад 20 гаруй шашны урсгал буйн зэрэгцээ уламжлалт бус урсгалын* 70 шахам сүм хийд, төв Монголд ажиллаж байгаа⁷ нь соёлын ба шашин хоорондын зөрчил дэгдэж болзошгүйг харуулж байна. Ийнхүү манай улсад гадны янз бүрийн шашны урсгалууд хүч түрэн орж ирж буй нь бидний хэдэн монголчуудыг эгнээндээ нэгтгэн эртнээс нааш сүсэглэн шүтсээр ирсэн буддын шашны нөлөө буурахад хүргэж буй нь бидэнд төдийгүй гадны сэтгүүлчдийн⁸ ч нүдэнд өртсөөр байна. Харин энэ байдлыг *“Монголын нийгэм төлөвшиж чадаагүй, залуус нь учраа олохгүй байгаа үед шашны үзэл суртал нэвтрэх хамгийн боломжтой орон зай бол Монгол”*⁹ гэж тайлбарлаж байна.

Бидний цөөнгүй хэсэг өнөөдрийг яаж өнгөрөөх вэ, маргааш хэдэн хүүхдээ яаж хоолтой хонуулна даа гэсэн аж амьдралын өдөр тутмын асуудалд санаа зовж, сэтгэл гутарч явдаг. Үүнийг далимдуулж шашны сургаал номлолыг ухуулан, итгэлийг нь олж авах нь бий. Зарим шашны номлолд “Үхэл гэдэг бол амралт, тарчиг

* Христийн шашны урсгалуудад: үнэн алдартан, католик, евангел, протестантизмаас гадна антихристийн гэгдэх мормоны, мүүнийн, иеговын гэрчүүд г.м.

⁷ “Глобальчлал, Монгол улсын хөгжил” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2002, УБ, тал 191.

⁸ ВВС-гийн “Asia Today” нэвтрүүлгийн 2003 оны 8 сарын нэгэн дугаарт Монголд харийн шашны урсгал хүчтэй нэвтэрч, Буддын шашны нөлөө буурч буйг харуулав.

⁹ Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн сэтгэл зүйч С.Баасанбат

амьдарна гэдэг зовлон¹⁰ зэргээр номлодог гэнэ. Үүнтэй ч холбоотойгоор ертөнцийн эзэнтэйгээ уулзах нэрийдлээр амиа хорлох тохиолдол гарч буй баримт бий.

Ертөнцийг үзэхүй нь хэт туйлширсан олон бүлэглэлд хуваагдах нь ҮАБ-д ямар хор уршигтайг өнөөдөр энд тэндхийн зэвсэгт мөргөлдөөн харуулж байна. Монгол улс шашин, үндэс угсааны хурц маргаан, зөрөлдөөн гарах нөхцөл бүрдэх, түүнчлэн үзэл бодол, үндэс угсаа, сүсэг бишрэлээрээ явцууран бүлгэрхэх, талцах явдлыг оршин тогтнохын болон нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдлыг хангахад сөргөөр нөлөөлнө гэж үздэг. Монголын хувьд шашин хоорондын мөргөлдөөнд хүртлээ хурцдахгүй юмаа гэхэд нийгэм болоод гэр бүлд шашны нөлөө, зөрчил их байна. Ганц жишээ татахад, ээж нь буддын шашин шүтдэг, охин нь христийн шашинтан болчихоод ээжийнхээ бурхан тахилыг шатаасан тохиолдол ч гарчээ. Ийм төрлийн асуудлаас хэрхэн сэргийлэх вэ? Монгол улсын хувьд шашин шүтэх, эс шүтэх нь Үндсэн Хуулиар олгогдсон хүний салшгүй эрх. Нэгэнт хүний үзэл бодол, шүтэн бишрэх эрхийг хуульчилсан болохоор бүхнийг хязгаарлах, хориглох боломж үгүй. Ийм нөхцөлд орон зайгаа эзлүүлэхгүйн тулд уламжлалт шашин, сүм хийд, шашны зан үйлд шинэчлэл хийхийг цаг үе маань шаардаад байгаа юм биш биз. Монгол улс Үндсэн Хуулиндаа: *“нэг талаас үндэсний түүх, соёл, уламжлалт монгол иргэншилээ нандигнан эрхэмлэж, нөгөө талаас, бусад улс түмний соёл, иргэншлийн шилдэг ололт, үр шимийг хүндэтгэн үзэх үндсэн дээр эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлоон хөгжүүлэх”*¹¹-ээ тунхаглаж, харин Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулинд: *“Төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэх үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ. Энэ нь иргэд бусад шашин шүтэхэд саад болохгүй”*¹² хэмээн хуульчилсан. Өнөөгийн монгол иргэншил, түүний дотор бурханы шашны уламжлал, шинэчлэлийн асуудлыг судлан авч үзэхдээ ч онол-аргазүйн хувьд чухам энэ л үзэл баримтлалыг үндэс болгох учиртай. Ер нь Монголын нийгэм - улс төр, эдийн засгийн өөрчлөлтөд шашны хүчин зүйл ямар нөлөөтэй байх нь *нэгд*: буддын шашны өөрийн шинэчлэгдэх байдал; *хоёрт*: христийн болон бусад шинэ шашнуудын монголын амьдралд үзүүлэх нөлөөлөл; *гуравт*: тодорхой асуудлаар шашнуудын ойлголцол зөвшилцөл, хамтын ажиллагаа хэрхэн өрнөхөөс хамаарна.

¹⁰ Монголчуудын сэтгэл зүй гутралын үерүүгээ явж байна 2003

¹¹ Монгол Улсын Үндсэн хууль 1998

¹² Монгол улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль 1993

Даяаршлын үр дагавар болсон мэдээллийн технологийн хөгжил, түүний дотор интернетийн сүлжээ залуучуудад боловсрол, мэдээлэл хайх хэрэгсэл болохын зэрэгцээ мэдээлэл хязгааргүй тархах, садар самуун явдал, гэмт хэрэг, хүчирхийллийг өргөн хүрээтэй, хараа хяналтгүй сурталчлах хэрэгсэл болж байгаа нь монгол хүний сэтгэл зүйд хүчтэй нөлөөлж, улмаар нийгэмд ёс суртахуунгүй, эмх замбараагүй явдал гарах үндэс болж байна. Хүүхэд залуус ялангуяа шинэ зүйлийг тусган авч, гадны нөлөөнд амархан автагддагийн хувьд тэдний дотоод ертөнц, үзэл бодол, зан авирт нөлөөлж, улмаар нийгэмд гэмт хэрэг, хүчирхийлэл ихсэх явдлыг нэмэгдүүлж байна. Энэ байдал нь дахин хуулийн хэрэгжилт сул буйг харуулж байгаа юм. Тухайлбал: ҮАБ-ын үзэл баримтлалд: *“түүх, соёлын үнэт зүйлс хууль бусаар гадаадад гарах нь Монгол соёл иргэнийн аюулгүй байдлыг хангахад сөргөөр нөлөөлөх бөгөөд энэ төрлийн зөрчил үйлдэхээс сэргэмжлэнэ”¹³* хэмээн заасны дээр Монголын хүн ардын ёс суртахуун, сэтгэл санаанд сөрөг нөлөө үзүүлэхүйц садар самуун сурталчлагч зүйлсийг зөвхөн хууль зүйн хүрээнд тусгай журмын дагуу хэвлэн нийтлэхээр зааж, Монгол улсын тусгаар тогтнол, монгол соёл, зан заншилд харш мэдээллийн түрэлтээс сэргэмжлэхийг анхааруулсан байдаг. Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулинд: *“Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлах, сурталчилсан хэвлэл, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэх, тараах, борлуулах, хадгалахыг хориглох”¹⁴* -оор заасан. Үүний зэрэгцээ холбогдох газрын зөвшөөрөлгүй садар самуун, хүчирхийллийг сурталчилсан ном, хэвлэл, гэрэл зургийн хальс зэргийг хилээр нэвтрүүлэхийг хориглон, хуульчилж өгсөн боловч Монголын түүх, соёл, шашны холбогдолтой үнэт зүйлсийг хууль бусаар улсын хил нэвтрүүлэх оролдлого цөөнгүй гарсаар байна.

Монгол улс “Хүн амын бодлого”-доо хүүхэд залуусын талаар баримтлах бодлогоо тодорхойлохдоо: *“хүүхдийг үндэсний соёл иргэний, ёс заншил, уламжлалынхаа мөн чанарыг дээдлэн хүндэлдэг иргэн болгон хүмүүжүүлэх ...залуучууддаа эх хэл, бичиг үсэг, ёс заншил, соёл иргэний, удмын сангаа дээдлэх үзлийг төлөвшүүлэхэд чухалчлан анхаарна”¹⁵* хэмээн онцлон тэмдэглэсэн нь бий. Үнэндээ ч үндэсний бичиг соёлыг уламжлан хөгжүүлэх, ёс заншил, сэтгэл зүйн аюулгүй байдлыг хангах цогц механизмыг бүрдүүлж, орчин үеийн эрэлт шаардлагад

¹³ Аюулгүй байдлын үзэл баримтлал 2002

¹⁴ Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль 1998

¹⁵ Монгол Улсын Хүн Амын бодлого 1996:22-р тогтоол

¹⁶ Глобальчлал, Монгол улсын хөгжил эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. 2002. УБ

нийцүүлэн түүнийг боловсронгуй болгох нь даяаршлын нөхцөлд үндэсний аюулгүй байдлыг хангах нэг төрлийн сэжим мөн. Энэ асуудал ч Монгол улсын хөгжлийн өнөөгийн нөхцөлд өвөрмөц байдалтай тавигдаж байна.

Даяаршиж буй өнөө үед дэлхийн соёл иргэншлийн сүлжээнд идэвхтэй оролцохын тулд олон улсын түгээмэл хэрэглээний гадаад хэлийг сурч эзэмших, тэдний соёл, зан үйл, ёс суртахууны хэм хэмжээ, сэтгэлгээг нийтлэг хүлээн авч ашиглах нь нэг ёсны дэвшилтэт үзэгдэл. Харин бидний хэдэн монголчууд *“чихнээ чимэг болсон”* төрөлх монгол хэлээ гадаад үгсээр ядууруулан зэрэмдэглэх, учир утгыг нь ухаж ухаарахгүй гадны соёл, сэтгэлгээний өнгөн тал, үзэгдэх загварыг мухар сохроор хуулбарлан дуурайж таарахгүй. Энэ нь улс үндэстнийхээ үндэсний онцлог, соёлыг таниулах хүчин зүйл болох эх хэлний мөн чанар алдагдахад хүргэж болзошгүй юм. Үүний дээр монголчууд бид англи үгсийг шууд хэрэглээд явахыг хичээхийн дээр латин үгсээр солих, улмаар Монгол улсаа хурдан даяаршуулах нь хөгжлийг түргэтгэх ач холбогдолтой гэж үзэх болжээ. Ойлгох ойлгогдохгүй англи үгс, орчуулгагүй кирил үгсээр бичсэн харагдах дэлгүүр, цэнгээний газрын хаяг нь хүртэл, мөн спортын нэр томъёо, урлаг үзвэр, улс төр судлалд ч харь хэл дээр бичигдсэн байгаа нь өөрийн эрхгүй нэгийг бодогдуулам. Хэл устана гэдэг нь тухайн угсаатан үндэстэн устаж, мөхөж байгаагийн илрэл болдгийн хувьд үндэсний хэлийг цэвэр ариунаар хадгалах нь зөвхөн соёлын төдийгүй, ерөөс үндэсний аюулгүй байдлын асуудал мөн.¹⁶ Гэвч нөгөө талаар үндэсний соёл, сэтгэл зүйн уламжлал, эх хэлээ цэврээр нь хадгалж байна гээд гадны бүхнийг эсэргүүцэх гэвэл бид дийлэхгүй, болох ч үгүй.

Соёлын даяаршлын үйл явц өнөөгийн хэлбэр, чиглэл, эрч хүчээрээ үргэлжлэх аваас монголын ард түмний үндэсний соёлын ноён оргил болсон нүүдэлчдийн соёлын өмнө орших, эс орших асуудлыг дэвшүүлэн тавих нь гэсэн айдас ч төрж буйг нуух юун. Ийнхүү улс үндэстнүүдийн соёлын ялгааг арилгаж, нэгдсэн нэг соёлт амьдрал төлөвшүүлэхийг зорьж буй соёлын даяаршлын өнөө үед улс үндэстний соёл иргэншлийн, цаашилбал үндэсний аюулгүй байдлыг хангах асуудал урьд урьдаас илүү чухлаар тавигдаж байна.

Соёлын тогтвортой хөгжил гэж өнгөрсөн түүх, уламжлалыг хадгалах, ингэхдээ орчин үе болон ирээдүйн чиг хандлагатай зохицуулан цааш хөгжүүлэхийг хэлдгийн хувьд үндэснийхээ соёл иргэншлийн суурь дэвсгэр дээр түүний тулгуур үндэс язгуурыг хөндөлгүйгээр суурин соёл иргэншлийн дэвшилтэт үнэт зүйлсийг

өөрийн онцлог, нийгэм-үндэсний өвөрмөц сэтгэлгээнд тохируулан өвлөх замаар өрнийн ба дорнын иргэншлийн дэвшилт ололтыг хүлээн авч, улс үндэснийхээ хөрсөнд суурилуулан хэрэгжүүлэх ухаалаг арга замыг боловсруулж, төрийн бодлогынхоо стратеги болгон баримтлах нь монгол соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлнэ гэж үзэж байна. Ер нь хуучин соёлоо тэр чигээр нь аваад явна гэвэл даяаршлын энэ үед зохицохгүй, нүүдлийн соёл иргэншил, амьдрах хэв маягт өдөр ирэх бүр өөрчлөлт орж буй өнөө үед ч энэ нь боломжгүй. Иймд өвөрмөц онцлогоо хадгалахыг хичээхийн зэрэгцээ түүнийгээ орчин үеийн техник технологитой хослуулах хэрэгтэй юм.

Улс, үндэстэн бүр өөр өөрийн онцлог, өвөрмөц ашиг сонирхол, хэл соёлоо дээдлэн эрхэмлэхийн зэрэгцээ бусад улс үндэстний онцлогийг хүндэтгэн үзэх нь төрийн бодлогын, иргэн нэг бүрийн ч сахих чухал зарчим. Чухамхүү даяаршлын нөхцөлд үндэсний соёлын орших, эс оршихын асуудал бол төрийн тууштай бөгөөд шинжлэх ухааны үндэстэй зөв бодлогоос шууд шалтгаалах нь ойлгомжтой. Иймд төрийн бодлого гэдгийг зөвхөн тунхаглан зарлах утгаар бус, нийгмийн амьдралд баримтлах зарчим, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үр дүнгийн цогцлол гэсэн утгаар авч үзэх цаг нэгэнт болжээ. Манай улс сүүлийн арваад жилд “Монгол Улсын төрөөс баримтлах соёлын бодлого”, “Соёлын тухай” болон “Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай” хуулиудыг батлан гаргасан боловч, тэдгээрийг хэрэгжүүлэх механизм нь боловсрогдоогүй учир тунхаглалын чанартай байгааг тэмдэглэвэл зохино. Цаашид ч хуульчлан баталгаажуулах шаардлагатай олон асуудал байна.

Соёлын даяаршил улс үндэстнүүдийг нэгдсэн нэг соёлт амьдралын хэв маягт шилжүүлэхийг эрмэлзэж, улс үндэстний соёл иргэншлийн, цаашлаад үндэсний аюулгүй байдлыг хангах асуудал урьд урьдаас илүү чухлаар тавигдах болж байгаа энэ үед манайх шиг жижиг үндэстэн үндэсний соёлоо дээдлэж, хайрлан хамгаалж, уламжлан авч чадахгүй бол хялбархан уусч, алга болж мэдэх тул энэ мэт олон багц асуудлыг үндэсний соёл иргэншлийн аюулгүй байдлын тухай ойлголт, бодлого, үзэл баримтлалтай харьцуулан эргэн нэг харж, чиглэсэн зорилготой бодлого боловсруулж, чандлан хэрэгжүүлэхийг эрхэм болгохын сацуу өнөөгийн бодит байдалд нийцсэн зүйл заалтыг нэмэлтээр тусган эрх зүйн үндсийг нь бий болгохгүй аваас Монгол үндэстний соёл иргэншлийн өвөрмөц дүр төрх бүдгэрч, улмаар харийн соёлд уусхад хүргэж болзошгүйг үгүйсгэх аргагүй юм. Энэ нөхцөлд Монгол улс үндэсний язгуур ашиг сонирхлоо харгалзсан, олон улсын харилцааны өнөөгийн

байдал, ирээдүйн өрнөлтийг урьдчилан харж чадсан, аюулгүй байдлын баталгааг хангах цэгцтэй бодлого боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгтэй болж байна. Тус ажлын хүрээнд дэлхийн монгол судлалын цөм, тулгуур багана болсон бүтээл туурвилаа өнө мөнхөд хадгалан хөгжүүлэх үндсийг тавьж өгөх нь зүйтэй. Ингэснээр ирээдүй хойч үеийнхэндээ эх оронч үзлийг төлөвшүүлэхэд бага боловч дөхөм болж өгөх юм.

Эцэст нь тэмдэглэхэд бидний монголчууд дэлхийн цараар сэтгэж, нутгийн хэмжээнд хийж бүтээн¹⁷, соёлын уламжлал, шинэчлэлийг хослуулах нь даяаршлын үйл явцад өөрийн эзлэх байр сууриа баттай тодорхойлох урьдач нөхцлийг бий болгох ач холбогдолтойг ухамсарлахын зэрэгцээ харийн бодлого, соёлыг тэр чигээр нь хуулбарлах бус харин өөрийн улсын онцлогт тохируулан, авах гээхийн ухаанаар хандах аваас зохилтой ажгуу.

As the process of cultural globalization intensifies having a strong influence on the culture and customs, tradition and religion of the countries the influence of cultural globalization on the national unique civilization of Mongolia has become a major concern for the people who are proud of the Mongols' history and culture.

Day by day Mongols not only tend to wear clothing, apply techniques and eat food like those of the Westerners but also try to speak and even think like them. This is a clear evidence of a strong influence of "Globalization", "Westernization", "Americanization" and "McDonaldization" in the Mongolian society today. Thus, the process named cultural intervention is likely to eliminate the cultural diversity of countries and to form a joint diverse assimilated way of life. Moreover it makes the humanity similar not only in terms of consumption but also similarity of lifestyle.

Due to introduction of numerous non-traditional religious sects in Mongolia a number of posing challenges need to be legitimized at the frame of the relations between the state and temples as well as inter-religious relations. The author stresses that the impact of religious factors on the socio-economic changes in the Mongolian society will on the one hand depend on the revival of Buddhism. On the other hand, it will depend on the influence of Christianity and other new religious denomination on the Mongolian life. Moreover mutual understanding on the specific issues and the cooperation among religions will play a key role.

¹⁷ "Think globally and act locally"

As there is a dramatic change day by day in the nomadic civilization and way of life, we can not survive our traditional culture without adapting it to the drastically changing environment. Thus, we need to keep our unique peculiarity while combining it with the modern Hi-Tech.

In the researcher's view, the main principles on the respect of unique peculiarity, national interests and culture of motherland and the respect of others' peculiarities need to be reflected on the state policies and adhered by the individuals.

To sum up, we, the Mongols need to understand that a combination of the traditional culture with the contemporary one will play a vital role in laying the prerequisite for the determination of its position in this era of globalization. Finally, the researcher highlights the saying "Think globally and act locally" while stressing that the alien policy and culture can not be just spontaneously replicated without adapting it for its own unique culture.